

УЛААН ХАМБАН ЗОДОГТ БУЮУ ТАВЫН ДАВАА

Хууччуулын өгүүлэхийг сонсвол монгол газар бөхийн удам тасрахын учир үгүй гэлцэнэ.

1

Өгүүлэх нь: Улаанбаатараас баруун урагш холгүй орших Буянт-Ухаагийн уужим талбайд өнгө өнгийн асар майхан хаяа хаяагаа дэрлэх шахам ярайжээ. Тэдгээрийн дундуур гоёж гоодсон хүн зон, машин тэрэгтэй хийгээд морьтой, явганаар нааш цааш тасралтгүйеэ сүлжинэ. Хөлтэй болгон хөдөлсөн эл талбайгаас навч ногооны хурц ааг, айраг сархдын исгэлэн үнэр хамар цоргин ханхлах ажээ. Энд ч хүүхэд багачуудын гийнгоо, сурын уухай хадаж, тэнд ч «бөхчүүл зодоглоод», «бөхчүүл зодоглоод» гэж засуулчид хоолой мэдэн дуудаж сонстоно.

Асар майхныг ч, бөхийн дэвжээг ч наадамчид хөл тавих зайгүй чигжин хүрээлжээ. Наадмын талбайн хойд талд «Төв асар» хэмээх нар хурын хамгаалалт бүхий бөгөөд туг дарцаг алаглан намирах байрны гол суудалд дарга сайд нар, зочид гийчид, суудлаа тухлан эзлэв.

Үүний хамтад «Төв асрын» өмнө, наадмын талбайн хойморт байрлуулсан алтан соёмботтөрийн далбаа өндөр өргөгдөж Ардын хувьсгалын... жилийн ойн их баяр наадам нээгдсэнийг зарлан цэлмэг хөх тэнгэрт алгуурхнаар намирлаа. «Төв асар»-аас монгол ардын уртын дуу «Түмэн эх»-ийг нарийн цээл хоолойтой дуучин бүсгүй хадааж:

*«Зэй хүй, Эрдэнэт хүний биеийг олж
Этгээд буруу үйлээс зайлж
Эцэс ба эдүгээгийн хоёр хэргийг бүтээхэд
Бүрэн сэдэлтэй зэ, зэ хүй ээ...»*

*Эртний ариун буянаа
Элбэгжүүлэн нэмж
Эсэргэн мэндийн бэлгээр
Хуран чуулж
Үүнээс хойшид нь
Зэ хүй улам улам өрнөхийн
Бэлэг мандах болтугай зэ»*

хэмээн дуулав. Хурдан морьд уралдааны гараа руу хөдөлж, бөхчүүл барилдааны талбайд гарахад дуулдаг уламжлалтай тул эл дууг жил жилийндолоодугаар сарын арван нэгэнд хийдэг монголын үндэсний их баяр наадмын оршил сүлд дуулал гэж нэрлэж ч болмоор.

Энэ дуунд наадамчин олны зүрх сэтгэл догдолж, бөхчүүлийн цог хийморь сэргэн бадардаг билээ. Наадмын талбайн баруун зүүн жигүүрт эрээлэн ханхайж харагдах монгол үндэсний угалз мэтгэсэн асраас зодог шуудагт бөхчүүл хан гарьд, халих бүргэд, харцага шонхрын дэвэлтээр дэвэн дэвсээр хоёр эгнээлэнзайтайхан зогссон засуулуудын дэргэд ам учраагаа дагуулан гарч ирлээ. Газрын хол, усны уртыг эс хайхран аймаг аймаг, сум сумнаас ирж энэ жилийн наадамд барилдахаар онооны цэцэд нэрээ бичүүлсэн нэгэн мянган хорин дөрвөн бөхийн түрүүч магнай ийнхүү наадамч олонтойгоо нүүр учрав. Зүүн талын магнайд хуучивтар улаан хамбан зодог шуудаг, дөрвөн талт малгай өмсөж шаа угалзтай монгол гутлаа бат баглаж боосон янхигар хөх өвгөн гарч ирсэн нь наадамчин олны анхаарлыг эрхгүй татав. Хавирга нь завсаргүй, харцага нь үегүй мэт авч нуруу нь ялимгүй бөгтийж, мах мариа нь шуугдсаны учир өмсгөл бүхэн нь түүнд элбэгдсэн мэт халхайна. Түүний онигор нүд, монхор хамар, урт түүшин, уужим магнай, навчин чих, нарийнбүсэлхий, түхгэр чээж, урт гар, өргөн аарцаг, уудам салтаа, том тавхай нь яах аргагүй сайн бөхийн дөрвөн шинж бүрдсэний гэрч ажээ. Гал нь буурсан нүдээрээ асрын алс дээхнүүртоомсоргүйхэн ширвэн халиах аралтайханөвгөнийг үзэгч олон, эвэртэй тэмээ үзсэн мэт гайхан шохоорхжээ.

— Энэ чинь хуучин Сайн ноён ханы Насан арслантай гараа дэвээ нь яасан адилхан юм бэ! гэж нүдэндээ итгэж ядсан нэгэн өвгөний өгүүлснийг батлах мэт түдэлгүй радио хоолойгоор «Зүүн талын магнайд Насан арслан...» гэж зарлах нь тэр ээ. Ингэж нэр алдар нь тодрох арслангийн гялалзсан уран шалмаг барилдааныг мэдэх үзэгч, бөхийн хорхойтон шөнийн од шиг олон авч ойрын арав гаруй жил нүд хужирлаагүй нь гарцаагүй үнэн. Насан арслан элэг бүсээ чангалан барууны магнай тийш хараа бэлчээн учраа залууг ажсанаа засуулаа ганхтал хойгуур урдуур нь шаван тэмүүлж, хан сарьдгийн оройгоос өвгөн бүргэд халин дэгдэхийн сүр хүчийг илтгэн зогсоно. Өвгөн бүргэдийн сүр жавхланг улам сэргээн нэмэх мэт:

*«Уяхан замбуу тивийн нар аа!
Орчлон хорвоогийн амьтад цугаар
Уулзан золгохыг яарсаар байтал
Огторгуйн үүлний цаадтай
Саатан хоргодохын учир юу вэ?
Та мину зэ*

*Энэ орчлон хорвоогийн амьтад аа!
Үүлний цаадтай хоргоддог минь
Энэхэн дэлхийн та нар цугаар
Ариун тунгалгийг мөрөөдөх атал
Үйл явдал эрээн барааны адил биш үү!
Та мину зэ»*

гэсэн дууны аялгуу «Төв асар»-аас ахин хангинаж эхлүүт засуулууд малгайг нь аван бөхчүүлээ тавилаа. Эл дуу, даваа давааны бөхчүүлийг тавихын дохио болон дуурссаарирсэн уламжлалтай билээ.

Уртын сайхан дууны уянга эгшиглэнд угтуул бөхчүүл ам учраагаа дагуулан «Төв асар»-ын зүг хурд хуваан гүйв. Тэдний дунд Насан арслан ажиггүй дэвэн дэвсээр «Төв асар»-ын өмнө очиж ёслон, гуягаа ор мөр гартал хэд алгадаад эргэлээ. Бөхийн дэвжээний төв дунд өрж зогсоход ам учраа залуу бөх, арслангийн өөдөөс алгаа үрчин ойртов.

Энэ хүүгийн ухас ухасхийх, зоримог шийдмэгийг харсан Насан «Богд хааны долоон хошуу даншиг» хэмээх их наадамд анх зодоглосноо арга буюу нэхэн санахад хүрчээ. Хээр талд сувдан цагаан сүргээ хариулж явтал, байр байдлыг ажиглавал бөхчүүдийнх бололтой нэгэн хөсөг Насан хүүтэй тааралдсан билээ. Ачаа хөсгийг дагаад байхлаар нь:

— Чи хонио орхиод наадамд явах санаатай юм» биш биз гэж хэн нэг нь алиалахад:

— Очиж үзмээр л байна. Даанч... гэж Насан өгүүлэн шүлсээ залгижээ. Эл үгтэйгээ л хамт залуу хүү зам дээр ганцаар үлдэв. Гэвч түүний сэтгэл, эргэлзэл тээнэгэлзлийнхээ уулзвараас огцомхон мултрав.

Насан хонин сүргээ гэрийнхээ гадаа тоос татуулан хөөж очоод айх, гайхах зэрэгцэн зогссон ээждээ «Би бөхчүүл дагаж наадамд явлаа!» гэж хариу хүлээх байдалгүй угсруулан хэлээд саяын хөсгийн хойноос зам хөөж, наадамчдыг даваан дээр гарахын үес гүйцжээ.

— Хүүе! Чи чинь юу болж явна? Буцаач! гэж нэгний өгүүлэхэд хүү толгойгоо маажин газар ширтэн гэлдэрсээр байв. Хөсгөөсзайдуухан яваа нэгэн эр нөхдөдөө хандаж:

— Мулгуу тэнэг юм болов уу? Буцахгүй бол яана даа! Гэр орныхон нь юу гэдэг бол? Эрж хайж сүйд майд болно доо гэж аяархан хэлэв.

— Харахад ухаан санаа нь эрүүл саруул бололтой юм. Хүүхэд болохоороо бөхийн дор тусаа биз гэж эмээл дээрээ хөндөлссөн ханхар эрийн өгүүлэхэд:

— Доной гуай! Тийм ч байж болно шүү. Гэсэн ч буцахаар горьгүй гэж нөгөө эр хэлэв. Тэгээд: — Уулын сүүдэр хүүшлэхээс өмнө буц! гэж аргадангуй хэлэхэд Насан зориг орсон бололтой:

— Намайг та нар аваад яваач! Би улсын наадамд очиж аманд гарч үзье гэж шивнэх төдий өгүүллээ. Үүнийг тосон авсан Доной:

— Эр хүний хүсүүштэй л хүслэн! Гэхдээ санаархсан бүхэн ч амд гардаг юм биш шүү. Аль вэ чи хаяж өгөөд эндээс түргэхэн буцаа гэжхөтчидөө тушаангуй хэлэв.

— За! гэж хэлүүт хөтөч хүү мориноосоо буун харайж ханцуйгаа шамлан өрөн зогсжээ. Насан, түүнийг барьж авуут ганц хавсран өвдгийг нь шороодуулав.

— Үетэй бянтай хүү байна шүү. За яах вэ, аваад явъя гэж Доной зөвшөөрөв. Насангийн сэтгэлд наран ургаж, бөхчүүлийн гар хурууны үзүүрт хайлсан тугалга шиг бөмбөрөн гүйх боллоо. Ингэж улсын их наадамд анх очсоноо санаад «Лав л зодог шуудаг нь сэнжлэн бариут атгаад авмаар томдсоныг үзэхэд өөрийн гэх бөхийн бүрэн хэрэглэлтэй болж чадаагүй нь ил. Миний арван долоотой үеийнх шиг алсын алсаас хөглөж ирсэн ч байж мэднэ дээ» гэж арслан бодов. Өвгөн арсланг амьсгаадуулах гэж залуу хүүгийн тойрч гүйхэд Насан тэвдсэн шинжгүй бат суурьтай зогсоно. Хүүгийн хавсраа мэх өвгөний хөлд гурвантаа хүрсэн боловч төдий л хөдөлгөсөнгүй ээ.

«Би ч гэсэн аманд анх гараад тэр нэгэн лухгар эрийг хийг нь тааруулалгүй хэчнээн ч хавсарч үзлээ дээ» гэж Насан арслан эргэцүүлэв. «Чамайг онооны цэцэд бичүүлсэн» гэж Доной зааны хэлсэн мөчөөс эхлээд л хавсрах мэхээ угтуул бөхөд хийх гэж Насан яалаа даа. Хөтөч залуутайгаа оройжин барилдаж «Хавсраа» мэхээ хийж түүнийг унагасаар байв. Махбод нь хөөн

томорч, бяр нь амтагдан, онгож хуучирсан хөх даалимбан тэрлэгтээ ч ханхар чээж нь багтаж ядан байх шиг Насанд санагдана. Хэний амд очлоо ч гэсэн түүнийг ганц хавсарч орхимоор бодогдоно. Хэзээ язааны том бөх шиг чээжханхалзуулан нааш цааш хөл хол алхан холхиж ч үзнэ. Оройн бүрийд наадамчид цугларч ирэхийн үес бөхчүүлийн хоол ундыг бэлтгэн суухдаа: «Надтай ганц барилдаж өгөөч гэж гуйвал яах бол?» гэж Насан бодно. Гэтэл түүний хүслэнг мэдсэн юм шиг Доной ирж:

— Чи ч бараг бидэнтэй л ноцолдмоор байгаа биз? Гайгүй ээ, гайгүй. Маргааш барилдана байх. Хэнээс ч болов айж сүрдэж болохгүй шүү. Шийдсэн мэхээ хийгээд л алдах онохоо үзэх хэрэгтэй. Аваргыг хаяж аварга болно гэсэн үг байдаг юм гэж зоригжуулав. Маргаашийн бага үдийн алдад Насан ч хөтөч хүүгийн зодог хэрэгслийг өмсөв. Зохиж таарч байна гэдэг өөрт нь захиж хийсэн юм шиг. Хүн болж төрсний хэрэг бүтэж байгаа мэт бодогдоно. Улам ч эр бяр нэмэх шиг. Гар хөлөө хөдөлгөвөл зодог шуудаг нь бариу ч юм шиг.

Өндөр нуруутай ханхар бөхийн аманд оногдож өрж зогсуутаа л Насан угсруулан дайрч хавсраа мэхээ хийв. Тэр бөх хүний урамд ядаж ганц удаа ч дайвсангүй. Нэгэнтээ ширүүлэн хөдлөхөд гурван хурууны өндөг түүний гуянд хүрэв үү үгүй юу л үнэгний сүүлэнд хууртсан адил Насан холоос хол гөдройтов. Атан тэмээнд тийрүүлсэн мэт санагджээ.

— Хүү минь нас бага, цус шингэн байна, хаясантай л адил гэж бод хэмээн засуул, Насангийн сэтгэлийг заслаа. Энэ үгийг цуутай бөхөд зоригтой мэх хийгээд унасан үед засуул хүн хэлдэг билээ. Элэг бүсээ тайлчхаад баруун талын асрын зүг гүйн явахад нь тааралдсан нэгэн бөх:

— Хүү, хэнтэй барилдав? гэхэд:

— Чойжоо гэсэн байх аа? гэж хариулав. Тэр бөх:

— Босоо Чойжоод уу? Хэцүүхэн ч эртэй учирч дээ гэв. Улс даяар «Босоо» гэж алдаршсан суут бөхийн хоч чимгийг барилдахын өмнө дуулаагүй нь яамай. Сонссон сон бол би лав ганц ч мэх тэр заанд хийж чадахгүй сэн биз гэж Насан сэтгэл дэнслэн боджээ. Үүнийг эргэцүүлэн санаад Насан «Энэ хүү ч мэх хийхийн л цул зориг яваа! Гэвч уявал энэ удаа над шиг өвгөнд бас ч осолтой байж мэднэ» гэж бодсоноо ухасхийн хүүгийн зодгоос сэнжлэн барив. Арслангийн хэд хэдэн хүчтэй халахад учраа хөвүүн барьцаа алдан газар онож гишгэхгүй болов. Ахин хүчлэн дугтраад түлхэхэд хүү бөгсөөрөө газарт тоос манартал лагхийтэл

суучхав. Ингэснээр ч Босоо Чойжоод Насангийн унасны үлгэр энэ удаа давтагдах мэт болжээ.

2

— Аав аа! Та үлгэрээ үргэлжлүүлэн яриаг гэж хүүгийн гуйхад эцэг нь зөвшөөрч ийн өгүүлэв.

«...Нусгай бор хүү далан мөрөн гаталж далан уул давж яваад Мангасын Тэвхэн хар гэгч бөхтэй таарч хүч мэхээ сорин барилдах болж гэнэ ээ. Хоёул тасын дэвэлтээр дэвж, хандгайн нүдээр хялайлцан, харцагын шүүрэлтээр шүүрэн барилцаж усгүй цөлөөс рашаан ундартал, устай газраас элсэн хайр оглортол ноцолджээ. Тэвхэн хар бөхийн далан дээрээс нь барьж далан гурав, гуя дээрээс нь шүүрч гучин гурав эргүүлэн ар нуруугаар нь агдлан тавьж Нусгай бор хүү дийлэв гэнэ ээ!»

Насан хүү зантгар толгойгоо гилжийлгэн амаа ангайж аавынхаа яриаг чих тавин чагнаж сууснаа гүн шүүрс алдаж

—Аав аа! Үлгэрийн баатар Нусгай бор хүү шиг тэнхээтэй бөх хэр олон байсан юм бэ? гэж лавлав.

— Хүү минь! Байлгүй яах вэ. Саяхан нэгэн зуун тавь жараад жилийн цаадтай 1821 оны үеэс Дорнодын талд нар, салхи амсан байж, чийрэг боргил өссөн Хүдэр гэдэг хүү айл айлд ачаа тээшний хүндийг өргөн зарцлагдаж явсан юм гэнэ билээ. Түүнийг баян айл илүү гэртээ унтуулахад ханын үдээс нь тас тас үсэрдэг байж гэнэ. Дахин үдэж өгөөд гэрийн эзний өглөө эртлэн босож ажиглахад Хүдэр хүү сэрүүтээ гараа алдлан суниахлаар ханын үдээс ахин шадшадхийн тасарчээ. Түүнээс хойш од харан хонож, орчлон дэрлэн унтагч болсон Хүдэр шүүдрийн ус дэгдэж дуусаагүй байхад шар хөллөн аргал түлшинд ганцаар явдаг болжээ. Гэтэл шарын хөлс цувж, туйлгүй их ядарч ирэх болсныг гэрийн эзэн бас анзаарчээ. Хүдэр аргал түлээгээ түүж дуусаад шараа тэрэгнээс мултлан унагаж босгончээжийг нь газраас хийлэн өргөж ноцолдсоор усан хулгана болтол хөлөргөдгийг мэдсэн гэрийн эзэн аргалах аргагүй болж «Долоон хошуу

даншигт барилд» гэж ятган түүнийг алс явуулах мэргэн ухаан сийлжээ. Хамт яваа нутгийн бөхчүүл айл хэсэж айрагдан Хэрлэнгийн усанд биеэ булхан зам гудас олон хоног саатах тул Хүдэр тэднээс тасарч ганцаар яаран оджээ.

Хэнтийн их хөвч дундуур нэвт гарсан замаар үдшийн бүрэнхийгээр шогшуулж явтал унасан морь нь гэнэт хамраа

тачигнуулан үргэжээ. Ажиглавал модон дундаас том хар юм сэрхийн гарч иржээ. Шуудхан халз дайрч ирэхлээр нь Хүдэр мориноосоо үсрэн бууж хоёр тараараа түүнийг чихдэж аваад доош хүчлэн дарж толгойгоор нь газар мөргүүлжээ. Муухай чарлах тэр амьтныг дар дарсаар боловч Хүдэр арга буюу босгочхов. Босуут савраараа Хүдрийн зүүн мөрийг буулгаж цус нөж цувуулжээ. Хүдэр түүнийг ахин овоодон авч хар хоншоороор нь газар мөргүүлэв. Ингэж Хүдэр, нутаг усныхны зүрхэнд орсон хорхойтсон баавгайтай ана мана, ач тач үзэлцсээр одод шуулгажээ. Нэг мэдэх нь ээнь хөвчийн тэр хүчит зэрлэг араатан хөл дээрээ босолтгүй болж хэдийнээ амьсгал хураасан байлаа.

Хүдэр зам даган алхсаар хөвч уулын бэлийн нэгэн айлд очиж удаан хоног асруулан тэнхэрсэн боловч тэр жилийн наадамд барилдаж чадсангүй. Хойтон жилээс нь эхлэн зодоглож Долоон хошуу даншиг, Богд хан, Хан Хэнтий хоёр уулыг тахиж хийдэг арван засгийн наадамд олон удаа үзүүр, түрүү авч явсан юм гэнэ билээ. Төр гэрэлтийн хорин нэгдүгээр оны даншигт¹ түрүү аваад буцаж явах замдаа хэдэн бөхчүүл хүчээ сориход Хүдэр үхрийн чинээ хар чулууг өргөн ургаа хадан дээр тавьжээ. Хожим хэн нь ч хөдөлгөж чадаагүй учир «Үүнийг Сан бэйсийнхушууны Хүдэр даян аварга «өргөж тавьсныг хойчийн хүмүүс мэдтүгэй» гэсэн бичгийг хэн нэгэн чулуучнаар сийлүүлсэн гэдэг юм.

Хүдэр даян аваргыг бие барсны хойно зодог шуудгийг нь манай нутгийн нэгэн сайн эр сэм хулгайлан авчирснаар Сайн ноён хан аймаг бөхтэй болсон гэлцдэг юм даа хүү минь!

Хүдэр даян аваргын хүнд алхаа Насангийн чихэнд сонстох шиг, түүний баавгайн савар шиг бахим гар нүдэнд нь харагдах шиг болов.

— За үг олдож, үхэр холдох нь байна. Өглөө эрт босож унага барина шүү, хүү минь гэж аавынхаа хэлэхэд:

— За, за! гэж дуугарсан ч Насангийн бодол санаа нь огт өөр зүйлд хулжсан байлаа. Тооноор од анивчихыг ажиглан хэвтэхэд Насангийн нүдэнд Хүдэр даян аварга ер харагдаад болохгүй байв.

«...Хүдэр даян аварга ярьж байна, сонсогтун!» гэж баргил бүдүүн хоолойгоор хэлэхийг хад асга хэдэнтээ цуурайтуулан давтав. Монголын алдар цуут Намжилжав аварга, Баянмөнх аварга нарыг залгах хувьтай төрсөн шөрмөстэй хүү байвал гараад ир ээ! гэж хүнгэнэхэд нь Насан урагш алхав

— Аль нутаг хошууны хэн гэгч вэ? гэж лавлахад:

— Сайн ноён хан аймгийн Насан! гэж хариу өчив.

— Насаан! Мөнх тэнгэр, алтан нар, хөрст дэлхийдээ өчил үг айлтгаж, хүч шөрмөсөө сэлбэж ав! гэж Хүдэр даян аварга дахин хүнгэнээд арслан алга болов. Насан, Хангай ханы орой дээр нисэх мэт дүүлэн гарч:

— Хөх тэнгэр минь ээ! Нарийн хураараа угаан, үүрдийн тэнхэл хайрла гэж гараа сунган өндөр дуугаар өчихөд огторгуйн үүлнээс намираа бороо шаагин асгарав.

— Алтан нар аа! Шижир цацралаараа гийгүүлэн мөнхийн тэнхэл соёрх! гэж Насанг гар сунгахад тэнгэр цэлмэж наран илч гэрлээрээ тэтгэв.

— Эх газар минь ээ! Буман үндсийн үржилтэй алтан хөрсөөрөө эгэл биед минь эсэн энхийн тэнхэл ивээ! гэж Хангай хандаа өгүүлэхэд Насанг цэцгийн үнэрт анхилуунсалхиараа таалав. Насангийн биед хурж цогцолсон тамир тэнхэл нь багтаж ядан байх мэт. Баруун гартаа Баян хайрхныг, зүүн гартаа Зүрх хайрхныг барин дэвж гарлаа...

— Зөв, зөв! Чи алтан нарыг атгаж, хөх тэнгэрийг мөрлөж, хөрст газрыг хөлөөрөө тулсан болохоор хэнд ч, хэзээ ч дийлдэх учиргүй. Миний санаа амарлаа хүү минь! гэж Хүдэр даян аварга хүнгэнэв...»

— Хүү минь, босооч! Унага уях гээд аав чинь зэлэн дээрээс дуудаж байна гэж эхийнхээ хэлэхэд Насан зүүдэндээ харамсан, нүдээ нухлан өндийв.

Адуун дундуур явж байтал ороо хээр үрээ Насангийн өмнүүр шүргэх шахам давхив. Ухасхийн хур дэлээс нь шүүрч авсан Насан түүнийг ташаалдаж газарт пидхийтэл унагаад:

— Ногт аваад ир! Түргэлээрэй гэжээ. Хүч тамир сорих ийм сургуулийг Насан хүү гүүн зэл, сүргийн бэлчээрт уйгагүй хийжээ. Энэ бүхнийгэргэцүүлээд «Тэр үед ч миний ташаа овоо л байсан. Одоо энэ залууд ташаалдах мэх хийж барах болов уу?» гэж бодов. Насантай хоёрын даваанд барилдсан залуу ... цэргийн ангийнх бололтой. Бас ч шаггүй ноцолдолгоотойг үзэхэд анх зодоглоогүй нь лавтай. Цэргийн хүү Насангийн хөл рүү гүйх завдан халгаж ядах бололтой. «Хүүхдээр заалгаж хөдөлбөл ч хөгшин толгой нар харна гэсэн үг. Би эхэлж хөдлөх учиртай» гэж Насан бодно. Үүнийг мэдсэн юм шиг хүүгийн засуул «Аандаа ах чинь заагаад өгнө өө! Доороо суурьтай, дотроо бодолтой үзнэ шүү хө» гэж үг заана. «Тойгдох мэхийг одоогийн хүүхдүүд бараг хийхийг больсон. Түүнийг туршдаг

хэрэг үү. Тойгдоод эс хөдөлбөл хөлөө татуут нь хий муриад үзэх үү» гэж Насан амандаа үглэнэ. Насангийн тойгдох мэхэнд Түшээт ханы Намхай аваргаас бусад нь тэсээгүй сэн билээ. Тэр мэхээрээ «Тойг Насан» гэж алдаршиж хоч чимэг зүүсэн удаа бий. Одоо тэр мэхний үүх түүхийг бодох цаг биш! Харин яаж хийвэл дээр вэ гэдэгтээ л ухаан зарах мөч! Өвгөн арслан ухасхийн тойгдтол хүү нэлээд ганхаж ирснээ тогтов. Энэ агшинд Насан хий муриут эргэтэл хүүгийн ташаа дотогшоо цөмрөв. Насангийн дархан тонгороод залуу ч эрхгүй ороод ирлээ. Өвгөн арслангийн дутуухан ачих гэтэл хүү сугарч үлдэх янзтай болов. Насан мэхээ өөрчлөхөөр шийдэв. Гэтэл цэргийн хүү зодгоос сэнжлэн бариут чирч гүйхээр завдав. «Гартаа яггүй бүлтэй юм байна шүү. Намайг чирч магадгүй. Тэгвэл би яах вэ? Өвгөн хүн өрсөхгүй бол горьгүй нь» гэж шийдсэн Насан дахин тойгдов. Учраа залууг зулзаган мод шиг ганхаад ирүүт нь ахин хий мурив. «Өвгөн минь давхар мэх угсарч хий» гэж өөртөө хэлүүт тонгорчих нь тэр ээ. Ташаан дээгүүр нь давж далаа шороодон татагдаж босохдоо залуу «Юу болов?» гэсэн байртай гайхаж нүдээ бүлтийлгэснээ элэг бүсээ тайлж Насангийн суга доогуур шурган тахимаа өгчээ.

3

Зуны зоосон шар наран Сонгино хайрхныцаагуур далд орох завдан, наадмын талбайд энэ өдрийн сүүлчийн гэрлээ харамгүй цацрааж байв. Талбайн төв дунд ноцолдох хоёр бөхийн сүүдэр алд дэлэм уртсаж зүүн талын асрын үүд хүртэл

сунан бараалах ажээ. Сүүдэр нааш цааш огцом хөдлөм хоёр тийшээ тасархайтан салав. Хоёр бөх барьц тавилцжээ. Засуулчид алчуур авчирч тэдний хөлсийг арчив. Насан засуулаасаа алчуурыг авч эгэм даган бөмбөрөх хөлсийг үрчинарчаад:

— Май! гэж эгүүлэн өгөв. «Оройн сэрүү уналтаар ингэж хөлсөө цувуулж зогсох ч гэж дээ. Энэ бөхтэй үд дөнгөж хэвийлтийн төөхөнсүүдэртэйд л барилцаж авсан. Одоо сүүдэр хаа хүрч вэ!» гэж арслан харснаа Насан биед чивчирч наалдсан зодгоо хөндийлөн сэвж сэрүүцэв. Наран сөрөг нүд гялбуулан харснаа «Хөөр хий муу аав минь:

— Миний хүү бага үдийн алдад их халуун наранд эхээс түрүүлгээ харж унасан юм шүү. Тэр үед агаар бүгчимдүүхэн байсан шиг санагддаг юм. Үүнийг чи бөхийн нэр зүүсэн цагтаа хэзээ ч мартаж болохгүй шүү

гэж байн байн хэлдэг сэн. Аавын энэ үгийн нарийн учрыг би сайн ухаараагүй явсан. Миний барилдахын их увдис үүнтэй холбоотой байжээ. Эхээс унахад тоссон бага үдийн наранд шаруулж, бүгчимдүүхэнагаараа амьсгалах үед ямар ч бөхөд унана гэж үгүй нь үнэн юм билээ. Түрүүлгээ унана уу гэхээс биш дээш харж хэрхэвч газардахгүй нь үнэн юм билээ. Үүнийг наадмын талбайд зодоглосон олон оны насан сүүдэр л надад хэлж өглөө. Энэ увдисыг ухаарсан үеэсээ үдээс хойш, бороо устайд барилдах дадал, түрүүлгээ харж унахгүйн дасгал хийх болсон сон. Тэр үеэс л миний барилдааны хий арилах шиг санагдсан сан» гэж Насан бодов.

— Өнөөдөр ч давалцах өнгөрөв бололтой. Маргааш өглөөний агаар амьсгал, нар гэрэл ч учиртай даа гэж шивгэнэж наадмын талбайн өмнө талын асарт суугаа хөлийн цэц рүү явсан засуулаа хүлээн холхино. Тэнд хүндэт суудалд улсын аварга, арслан цолтон хэд хэдэн бөх харагдана. Хөлийн цэц нь оноо хийж бөхийн маргаан таслах, барилдаан эхлүүлэх, зогсоох бүрэн эрхт шийд гаргана. Хөлийн цэцийн хариуг гагцхүү засуул сонсож бөхөд дамжуулна. Хоёр засуул уралдан ирж:

— Өнөөдөр наадам завсарлах боллоо! гэж зэрэг шахам өгүүлж өөр өөрийн бөхийг авч асрын зүг явав.

Өвгөн арслан майхандаа очиж морьдоо Туул голоос усалж явах зуураа «Мөнхөө гэдэг цахилгаан мэт түргэн хөдөлгөөнтэй залуугийн хөмсгөө зангидаж, хөмхийгөө зуусан байдал яахаас ч буцахгүй шинж илэрхий шүү. Тэр жил надтай учирсан бөхтэй тун төс нэгэн» гэж бодов. «Долоон хошуу даншигт тав давж улсын начин цол хүртэх жилээ нэг ширүүн бөхтэй Насан таарчээ. Барилцаж авуут нь л тасхийх чимээ гарч Насангийн зүүн хөл гишгэж болсонгүй, арай л нулимс гаргасангүй нүдээ аньж, шүдээ тас зуун засуулаа түшив. Засуул нь Насанг сугадан асарт аваачив.

— Заяагүй новш! Хүний хөл өвдгийг чинь өшиглөж байхад юу харж байсан юм бэ! Нүд цавчдаг хүн хэзээ ч сайн бөх болдоггүй гэж нутгийн бөхийн аашлахад:

— Аль вэ! Бушуу гүйгээд морьдын хазаараас хамгийн том зуузайтайг нь мулталж аваад ир гэж ахмад бөх хэлэв. Түүний хатуу чанга гартайг мэдэх Насан «Гол тасартал өвдөж байхад том зуузайтай хазаараар ороолгож баллах нь» гэж айх, өвдөх зэрэгцэж дуу тавин ёолж байв. Хазаар авчрав. Тэр бөх хумбан аяганы амсрын хэртэйдугариг хар зуузайг барьж үзсэнээ, хадгаар тойруулан ороож жийрэглэн тойгт

угласан нь өвдөгнийх нь нүдээр яг таарав. Тойгийг нь тал талаас нь дуу алдтал базлан шахаж зуузайг углан хадгаар татаж боогоод:

— Бушуу яв! Унаад ирвэл хохь чинь шүү, чамайг даа... гэжээ.

Насан нэгийгээ үзье гэж эрс шийдэж нүдээ ч цавчилгүй бөхийн өөдөөс ширтэнэ. Түүний хөл дахин цөмөрч ирэхэд ухасхийн шүүрч түрж гүйн гүйсээр арай гэж унагажээ...» Насан арслангийн нэхэн санасаар майхандаа иртэл үл таних өвгөжөөр хүн угтав амар мэндээ мэдэлцэж хэрэг зоригоо хэлж:

— Миний дүү тантай өдөржин ноцолдсон. Энэ жил улсын начин горьдож байгаа юм. Та өршөөвөл... гэж ам нээхэд тал тохой татаж ам авах, хэн нэгэнд бууж өгөхийг үнэн голоосоо цээрлэж «Эр хүний хийх хэрэг биш! Аз хийморьдмуу» гэж үздэг Насан:

— Би хэзээнээсээ ийм үг дуулах дургүй. Бөхийн цол гэдгийг чинь гуйж олдоггүй, гуядаж авдаг сан. Өвгөн хүнээс ингэж гуйж байна гэдэгчинь зүдэг хэрэг биш үү! гэж нүүр өгөлгүй ширэв татан суужээ. Нөгөөх өвгөжөөр хүнтүдэлгүй үг дуугүйхэн майхны үүдийг сөхөн гарч чиг зүггүй арилсан гэлцэнэ.

Наадмын талбайд өчигдөр оройн давалцаагүй салсан хоёр бөх ахин гарч ирлээ.

Аймгийн начин Мөнхөө, арслангийн өөдөөс гараа сарвалзуулан ухсалснаа огцом хон эргээд хол хол алхав. Чингэснээ алхаан дундаа гэнэт үсчин эргэж Насангийн шуудгаас шүүрч авах гэснээ больж годхийн зайлав. Мөнхөөг тойрч зугтахлаар засуул нь:

— Халуун юм биш. Бариад ав! гээд хонго руу нь хоёр алгдан түлхэв. Мөнхөө ахин гялсхийн харваж зүүн хөлд нь орох завдав.

Насан биеэ зайлж, барьцгүй цохив. Нүд ирмэхийн зуурт аймгийн начин зүүн мөрөө даран газарджээ.

4

Насан, Сумьяагийн зүүн хөлийн дотор талыг баруун хөлөөрөө гадагш хагалж цохин, түүнийг хүчтэй гуядуутаа л элэг бүсээ тас үсрэх шиг болохыг мэдэв. Элэг бүснээс нь тэнхээ мэдэн зуурсан Сумьяаг Насан өргөн босгов. Сумьяа аль ч учрыг олохгүй дэмий л элэг бүсээ тайлмаар завдсанаа, засуулаа хөлийн цэц рүү Насангийн засуултай уралдан гүйхийг харж, гайхаж эргэлзэв. Насан тахимаа авъя гэсэнгүй, элэг бүсээ зангидан зогсоно.

— Тасарлаа гэж бодсон чинь уяа алдуурчээ. Тэгнээ тэгнэ, тасрахын учиргүй эд юмсан даа гэж Насан шивнэснээ: — Заяаны минь хань Жаргал ур ухаанаа гарган хийж өгсөн, юмсан гэж дуулдмаар чанга хэлэв. Түүний нүдний өмнө Жаргал бүсгүй, он цагийн тэртээгээс инээмсэглэн үзэгдэх шиг болов.

— Миний хүү зодог шуудаг эсгэх нь үү! Зөвөө зөв! Өнөөдөр чинь хишиг өдөр шүү дээ гэж аавынхаа хэлэхэд Жаргал хоймрын ширдэг дээгүүрээ улаан хамбан торго дэлгэж, уран ээжтэйгээ зөвлөн байж Насангийн хуучин зодог шуудгаар үлгэр авав. Урт гарт нь ханцуй нь богинодох вий гэж төөлөн төөлөн хэмжсэн Жаргал уран хайчныхаа үзүүрийг хамбаны эн юунд хүргэв. Өргөн ханхар чээжинд нь багадчих вий! гэж далбаа юуг нь зөрүүлдэн тавьж эсгэв. Өрсөлдөх бөх дугтрахад цуучих вий гэж хамбандотор давхар тавьж хайчлав.

Сум шиг шулуун зүүндээ мяндсан бөх утас сүвлэж нуман гогцоо гарган татаж зодогшуудгийн угалз тов руу товшив.

«Хүзүүгээр нь жавар орно гээд
Хөвөнтэй дүүдүү хийгээд өгсөн юм аа
хө...»

гэж амандаа уянгалуулан аялж зодгийн оёо бүхэнд сэтгэлийн илч бяр юугаа шингээн урлана. Дийлэгдэшгүй их хүчтэй байг гэж ар зоо далбаанд нь бар, арсланг ноцолдууланхан барилдууланхан шаглав. Арслангийн нүд амьд юм шиг цогтой гялалзаж, сахал үс нь хөдлөх мэт болно. Түүний бардам түрэмгий хүрхрэлтсонстох шиг санагдана. Дайрч ирсэн бөх татахын цагт сунашгүй бөх, суларшгүй бат байг гэжнанжвандан хадгийг гурамслан элэг бүс хийв... Насан Жаргалынхаа хийсэн улаан хамбан зодог, шуудгийг өмсөж үзэв. Түүнийгээ байн байн барин үзэж:

— Яг таарч байна шүү гэж нүүр нүдэндээ баяслын цог бадруулан хэлэв.

— Ерөөл дүүрэн захиа сайхан таарчээ. Миний хүү нааш ир! Энэ жилийн наадамд бөх болж төрснийхөө ид хавыг гаргаж сайн барилдана шүү гэж буурал тэргүүнт өвгөн аав нь өгүүлээд Насангийн хацрыг үнсэв. «Насан туршид энгэр зөрж, дэр нийлэх сайн хань минь ээ! Ариун цагаан сэтгэлээ дэлгэн дэлгэж би амраг чамдаа арслангийн даваа бэлэндье» гэсэн ерөөлийг баяр гэрэлтсэн алаг нүдэндээ тодруулсан Жаргал мөнгөн аягатай сүүг аюуш хадгийн хамт барихад «Аав, ээж,

амраг хань, алтан нутгийнхаа нэрийг өргөн яваад л ирье» гэсэн итгэл дүүрэн харцаар халисан Насан аягатай сүүнээс амсан, бурхныхаа өмнө тавив.

— Бид орон гэрээ сахина. Та нар зорьсон хэргээ сэтгэлчлэн бүтээгээд ирээрэй гэж аав нь хэлэв. Насан, хурдан морьдын сойлгын шонд очиж, дэлийг нь сүмбэ шиг тэгш зассан зүс нийлсэн их бага хоёр загалыг эмээллэв. Ясан хяртай бүүрэгт нь тэнзэн ташуур эгэлдрэглэв. Жаргал хондлой давсан гээгтээ сувдан сар даруулга зүүж, үйтэн хуар дээлээ өмсөн, шар дурдан бүс жавхайтал ороогоод тогоо дүүрэн хөөрүүлсэн сүүгээ хөөсөртөл самарчээ. Насан Жаргал хоёрыг алсыг зорин хөдлөхөд аав, ээж ньаяны дөрөөг нь сүүгээр мялаан алтан шар зам өлзийтэйг ерөөв... Үүнийг бодоод Насан засуулчаа ямар үгтэй ирэхийг тааж ядан зогсоно. Элэг бүс алдуурсан учир Насан Сумьяа хоёрыг дахин барилдуул гэсэн шийдийг хөлийн цэц өгчээ.

— Нэг унагасан юм, дахиад хаяна аа арслан минь! гэж Насангийн засуулч өгүүлнэ. Олон мэх

даамай мэд дэгээс гадна өөрөө барилдаж явсан тэр хашир засуул, учраа бөхийн хийтэй гишгэлтийг гярхай ажиглаж түүний яаж хөдлөх гэж байгааг уран үг, далд утгаар зассан бөхдөө хэлж тусална. Тиймээс ч засуул:

— Арслан минь! Зоригтойхон хөдлөх болжээ. Тоосон дундаас хөл олж харахгүй гэх биш! гэж Насанд дайрч давшин барилдахын сануулга өгсөөр ажээ.

Насан ухарч ухарч ухасхийм Сумьяатайлавцав. Түүний гарын уртын хэрэг энэ мөчид л гарах учиртай. Чээжээ хийлэн биедээ хүчлэн татахад Сумьяа цахалж зүтгэсээр байв. Насангийн зүүн гар барьцгүй сул унжиж, өвдөгний нүдийг хааяа тулна. Сумьяа «Гар ачих» нь гэж бодоод «гуяны урд талаар хөшүүт гарыг нь гадагшлуулан цохино» гэж Насанг анана. Гэтэл Насан гар ачаа хийсэнгүй. Харин Сумьяагийн зүүн хөлийн өсгийнөөс хамж татан «Хар тавхайдах» мэх гүйцээн хийв. Насанг «Төв асар»ын өмнө дэвэн очиход засуул нь даган гүйж түүний малгайг өмсгөв. Арслан бөхийж хоёр гараа тосон бөхийн идээ авч дөрвөн зүг найман зовхист цацаж зүүн асрын зүг гүйв.

«Тээр жилийн долоон хошуу даншигт долоо даваад асрыг чиглэн Жаргалыгаа харж байхдаа би ямархуу түгшүүр сэтгэлдээ тээж явлаа?» гэж Насан өөрөө өөрөөсөө асуув. «Богдын Эх дагинын бөх Жамбааг Насан долоогийн даваанд хаяжээ. Хөлийн цэц дахин барилдуулахыг

тулгахад Насан ахин барилдаж цэвэр орхиж билээ. Эх дагинын таалал гажиж:

— Яагаад миний бөхийг зориуд удам судраар нь муучилж харц хархүү олны өмнө дахин дахин хаяж байгаа юм бэ. Яагаад би ганц бөх харж болдоггүй юм? Энэ наадмыг би үзэхгүй гэж босон харайжээ. Үүнийг аялдаж Богдыгбосохуйяа наадам ч завсарлажээ. Тэр явдлаас болж уг наадам хоёр хоног саатжээ. Тэгээд Насанг ёс эвдсэн гэж барилдаанаас хасаж, ялд унагаах болж хаад ноёд Богд, Эх дагина хоёрыг аргадан мандал өргөснөөр наадам үргэлжилжээ. Их загалаа хөтөлж, бага загалынхаа дөрөөн дээр өндөлзөн байсан Жаргал угтан очиж Насангийн ханхар чээжинд толгойгоо наан:

— Чи минь даанч яав даа! гэж нулимсаа залгин эхэр татав. Насан, Жаргалын өтгөн хар гэзгийг илж:

— Айвал бүү хий! Хийвэл бүү ай гэдэг юм. Яах вэ, нулимсаа татаж сэтгэлээ хатууж! Одоо

бидний ингэж зогсох цаг биш шүү! Чи минь зодог шуудаг ав. Бага загалаа хөтлөөд, их загалаа унаад одоохон нутгийн зүг гар! Энд удвал чамд аюултай! Чи минь ирсэн замаа мэднэ шүү дээ. Болгоомжтой яваарай! Аав ээжид болсон явдлыг хэлнэ биз гэж өгүүлсэн Насан хоёр загалын эмээлийг солих зуур:

— За! гэж толгой дохисон хэр нь ээ Жаргал енгинэтэл уйлсаар байв. Яг энэ үес:

— Насан заан хаа байна? гэсээр хиа тахар нар ирэв. Ингэж л энэрэлгүй засгаас шулуун шударга барилдсаныхаа «шанг» авч долоо давсныхаа «цолыг» хүртсэнээ Насан санаад:

— «Намайг гяндангийн хаалга татаж байхад чи минь зуузай холбон дөмөлзтөлөргүүлж ирсэн замаараа нүд дүүрэн нулимс, чээж дүүрэн гунигтай өнчин ганцаараа бага загалаа хөтлөн буцаж билээ! Хөөрхий минь» гэж шивнэв.

«Он цагийн урсгал дунд чи минь, одоо хаана ч алга! Гэвч чи минь сэтгэлээр гутахгүй тэмцэн хатуужихын ид шидийг наддаа заяажээ. Маргаашийн даваанд зэхэж байгаа зориг тэмүүллийн хүчийг чи минь хайрласан билээ. Харгис бурангуй, хувьсгалт гэгээн хоёр төрийн их баяр наадмын өдөр шөнө шиг ялгааг чи минь харсан ч болоосой, Жаргал минь» гэж өвгөн арслангийн зүрх цохилон авай.

— Дөрөв давсан бөхчүүл ирж амаа аваарай! гэж радио хоолойгоор хэдэнтээ давтан зарлах нь Буянт-Ухаа даяар цуурайтав. Эл зарыг

сонссон угтуул бөхчүүл онооны цэцийн зүг хэд хэдээрээ хөшилдөн алхална. Хэн хэнийг амлах ньнаадамчдын сонирхлыг хамгийн их татдаг билээ. Арга ч үгүй биз ээ. Тав давсан бөхчүүл шинэ цол чимэг нэмнэ. Тиймээс дөрөв давсан бөхийн хэний боловч зүрх түгшин цохилно. Ялангуяа алдар цолгүй бөхчүүл «хэний амд оногдоо бол?» гэж түгшин, чих тавин чагнадаг үе мөнөөс мөн. Нас сүүдэр өндөр зарим угтуул, өсөх идэр залуусыг амлан авч сайн бөх болох аяны алтан шар замыг ерөөдөг юм. Улаан хамбан зодгоо бүсэлсэн Насан онооны цэц рүү халбалзтал алхан очиж давсан бөхчүүлийн цэс ч харсангүй.

— Өвөрхангай аймгийн арслан Цоодолыг над дээр тавьчих! гэж шуудхан л хэлээд эргэжээ. Энэ үгийг сонссон хүн зоны дунд хоёр таавар дэгдэв.

— Аргагүй ээ, аргагүй! Нутгийнхаа хүүг улсын начин болгохоос өөр яах вэ гэж нэг

хэсгийн ярихад:

— Арслан гуай энэ жилийн наадамд Цоодолтой л барилдах гэж зорьж ирсэн юм гэнэлээ. Ёстой сонин барилдаан болно доо гэж зарим нь өгүүлэв. Үүний хоёр дахь таавар чухамхүү оносон ажээ.

Ноднин зун Өвөрхангай аймгийн наадамд Цоодол гэгч бие хараа сайтай залуу үзүүрт гарч иржээ. Тэр шороо атган, өрсөлдөгч, бөхийнхөө нүүр нүд өөд цацлан гүйн орж өргөж хаяхдаа хавирган дээр нь албаар гайхуулан өвдөглөж хүнд гэмтээн, босохдоо толгой дээгүүр нь харайн гарч бөх хүнд нийцэмгүй авир гаргажээ. Түүнийг үзэж суусан Насан тэсэж чадалгүй очиж:

— Дүү минь нар эрт, нас залуу байна. Энэ эвгүй зангаа тат! Сагсуу зан сайн бөхөд тушаа гэж мэд! гэжээ.

— Би сагсуудаа яагаа вэ? Танаар заалгахгүй ээ. Таны бөх явсны сургийг сонссоноос биш зодоглосныг чинь хараагүй юм байхчив. Ам бардан гуя шалдан болсон зөнөг юмнууд урьд балрын гавьяагаараа гай хуулцгаадаг юм. Ханатал сонслоо, үзлээ! Наад үгээ надад хэлснээс хаданд очоод хашхир! гэж Цоодол бие дээ хэр халдаахгүй байв. Энэ үгэнд арслан, яс махнаасаа гомдож:

— Ингэж чээж өргөж байж нутаг усны нэрийг гаргахгүй.

Барилдаж явсныхаа үнэн худлыг чамд мэдрээх нас тэнхэл хоёр даанч үлдсэнгүй дээ. Хойтон улсын наадамд барилдахыг чинь үзэх ганц жил надад хоцроогүй байгаа даа гэж гомдолтойхон хэлээд Насан Цоодолын дэргэдээс нүүр хийх газаргүй болж шалавхан холджээ. Аймгийн

наадмаас их л гутарч цөхөрсөн байдалтай уруу царайлан ирсэн арсланг үзээд гэрийнхэн нь ихэд гайхаж:

— Бие чинь зүгээр биз! хэмээн асуухад:

— Зүв зүгээр гэж өвгөн хариулжээ. «Би хорвоо дээр тоос хөдөлгөж явна гэдгээ үнэмшүүлэх л хэрэгтэй» гэж амандаа цаг ямагт бувтнана. «Хэн нэгэнтэй тур тархийж дээ» гэж гэрийнхэн нь гадарласан авч түүнээс онцолж лавласангүй. Насан гэртээ хэд хоноод сумын төв орж ирэхдээ:

— Энэ жил жинд явахаар хэлцлээ.Одоогоос зэхнэ гэж хэлжээ. Уг нь Насан жилалгасалгүй жин тээж аяны урт замд гардаг байснаа сүүлийн таван жил гэрээс холдож, гэдэс дундлаагүй билээ.

— Аав аа! Та юу болоо вэ? Хөхөө өвлийн хүйтэн, хөр цасны арвинд даарч хөрнө шүү дээ.

Яах гэсэн юм бэ! гэж хүүгийнхээ учирлахад:

— Жин тээгээд хөлдсөн хүнийг өдий хэр наслах даа би дуулаагүй л юм байна. Энэ чинь улсын ажил биш гэж үү! гэж амыг нь таглажээ.

— Танаар жин тээлгэлгүй бид халуун амиа бөөцийлөхтэй байна. Яах гэсэн юм бэ! гэж охиныхоо өгүүлэхэд:

— Аян жин хийнэ гэдэг чинь мөнгө олж, баяжихын нэр юм уу? Мөн ч нялхаараа байна даа, та нар! гэж сургамжилжээ. Тэгээд тэр намраа жингийн даамлаар алсыг зорин хөдөлжээ. Малгайн үс сэргээгээд ирэхлээрээ эр хүний хийморь сэргэдэг гэдэг үнэн юм. Насан жинд яваа нутгийн залуусын хэнээс нь ч хуруу дутахгүй ачаа тээшийг бярдан ачиж буулгана. Алхаа гишгээ нь хөнгөрч, яриа хөөрөө орж:

— Хүүхдүүд минь! Аян жин гэдэг чинь ёстой л эр хүний хийгүүштэй сайхан ажил юмхуна. Намайг бараг насаараа энэ замд явсан гэхэд худал гэх хүн таарахгүй биз. Ноцолдож явсан маань ч үүнтэй холбоотой байж мэднэ гэж хуучилна.

— Буудаллах уу, яах вэ? Та даарч хөрж явна уу? гэж нар шингэв үү үгүй юү залуусын эхэлж асуухад:

— Эр улс ийм үг ярьдаггүй юм. Зөвхөн л хоёр нарны хооронд яваад байх юм бол бид газар хороож энэ жил дээ жингээсээ харихгүй шүү дээ гэж Насан унтууцна. Үдшийн бүрий орчныг нөмөрч, өндөр тэнгэрийн одод өнгө нэмэн гялалзахад цэлхэрсэн нүднийхээ нулимсыг хаа нэг арчин үнэгэн лоовуузынхаа бүчийг тайланхан:

«Зэ, Алс холын замыг

*Алхаагаараа товчилдог
Ачаа жингийн хүндийг
Амархнаар нэвтрүүлдэг
Асар их хүчтэй
Атан олон тэмээ л мину зэ...*

*Зэ, Идэр жинчин биднүүд
Эрэмгий чадлаа гаргаж
Энх замын аяныг
Эрх тааваараа туулаад
Эх орны ардуудыг
Эд бараагаар хангацгаая зэ»*

гэж баргил хоолойгоор заримдаа аялчихсан алхлуулна.

— Урдах газраа шагайж, өмнөх замаа ширтсэн хүн жинчин болж бардаггүй. Аянчин хүн гэдэг хөндийн цаадах талыг, хөтлийн цаадах уулсыг нэвт хардаг учиртай гэж сэтгэлдээ эргэцүүлж ширээ хүрэн атныхаа сэвлэг зөөлөн зогдорт хацраа наан, түүний газар хорооцтойалхаанд эр биеийн чилээ гаргана. Шөнө дундаас өмнөхөн задгай амаар нь гал улалзсан аяны майханд жавар салхи амтагдсан хээрийн цайнд цагаан тос өрөм хөвүүлэн оочихдоо: «Энэ хорвоод тоос хөдөлгөж яваа гэдгээ би үзүүлэх л ёстой» гэсэн үгээ бас л давтаж нойр авахын өмнө хөсгийн дундуур алхаж, ачаа тэнг бярдан өргөж үзнэ. Эл үгийг Насан, жингийн ужиг урт замд үглэ үглэсээр гэртээ иржээ. Энэ үг өвгөнийг гэрт нь мөн ч олон хоног унтуулсангүй ээ. Өдөр бүхэн шахам буу үүрээд ой хөвч, хээр талаар тэнэнэ. Алсын алсад хаа нэгэнтээ бөөн утаа манасхийж цахиур бууны панхийх дуун гарч, хад асга дамжин цуурайтах авч Насан ганзагаа ангаар мялааж ирэх нь өдрийн од шиг ховорхон. Тийн яван явсаар бүр, усны цөн түрж уулын мод гөлөглөх үеэр үр хүүхдээсээ холдож, холын цэнхэр ууланд аяны жодгор барин гарчээ.

— Аав минь яаж яваа нь энэ вэ? Хүний үг авахаа больж, хүйтэн хярд майханд хийдэжхуйтаж хавагнах нь гэж хүү охин хоёр хэчнээн үглэвч Насан бас л үгэнд нь орсонгүй. Өвгөний ингэж дураар аашлах нь гэрийнхэнд төдийгүй нутаг усныханд гайхаш төрүүлжээ.

«Хөөрхий Насан солиорч уул хадаар хэдэн сар тэнэж яваа юм байх аа!» гэсэн яриа айлаас айлд дамжиж байв. Энэ үес Насан уулын өндрөөс том том хад, чулуу шидэж явжээ. Бууралтсан тэргүүнээсээ уур цан

савсуулан уул энгэрлэж явахдаа: «Түшээт ханыхаас зуу гаруй жилийн хойно цэгцэрч бий болсон авч манай нутгийн «Бөхийн сорилго» монгол даяарт доогуур орж яваагүй юм хуна. «Бөхийн сорилгод» хошуу, сум бүрээс хамгийн тэнхээтэй нь ирдэг сэн. Тэгээд Дамиран аварга, Гэлэг арслан нар үнэхээр уйгагүй ноцолдож гарыг минь зодогт хүргэж өгсөн сөн. «Бөхийн сорилгод» хувцаслах, гараа дэвээ мэх хийх, цол дуудах, бөх засах, биеэ авч явах тэргүүтнийг тун нягт заадаг сан. Сорилгын үед архи, уух, үүлэн борооны хэрэг үйлдэхийг шууд цээрлэж, шарх сорви, гэмтлээс сэргийлэхээс гадна шингэц удаан хүнд хоол идэхийг хорьдог сон. Хатуу дэвсгэр сэрүүн газар унтахыг заавал гүйцээлгэнэ. Бид банзан дээр нүцгэн унтаж

тэвчээрээ шалгадаг сан. Биднийг хүйтэн сэрүүн, жин халуун, хур бороо, салхи шуургатайд барилдуулж цаг улиралд дасган сорьдог сон. Айраг уулгах гэж хатуу хавраар гүү бариулдаг сан» гэж нутгийн бөхийн сургуулийн тухай нэхэн бодоод «Миний арслан болсон маань бөхийн сорилын ач! Аймаг, хошуу болгонд шахам заншсан энэ бөхийн тэр сорилго монгол нутагт мөн ч олон аварга, арслан, заан тодруулаа биз дээ. Би сайн бөхийн тоос үзсэн хүн шүү» гэж шивнэв. Маргааш нь гэртээ ирж:

— Хүүхдүүд минь хэдэн унага уяж, айраг эсгэе гэж шалав.

— Ийм эрт хэзээ гүү барьдаг билээ гэж хүүхдүүдийнхээ дургүйцэхэд:

— Барихыг та нар бариад аль! Би айраг эсгэх бүлэхийг даая гэж Насан хэлжээ. Үг чиггүй зүтгэхийг мэдсэн хүүхдүүд нь унага уяж гүүгээ барихаас аргагүй болжээ. Тарган ирэг гаргуулж шинэ шөл ч уув. Насангийн өнгө зүс сэргэн гялалзаж, үдэд айргаар булхан наранд шарах болсноос бие нь хүрэл баримал мэт гялалзах болжээ. Тэгээд улсын баяр наадам эхлэхээс сарын өмнө хуучирч онгосон зодог шуудгааавдраасаа авч адилсан, майхан тээшээ моринд ачаад хөдлөв. Ингэж л Насан энэ жилийн наадамд ирсэн бүлгээ.

Ам учраагаа аваад Насан майхандаа ганцаар бодолд автаж «Хорвоод тоос хөдөлгөн яваагаа үзүүлэх л ёстой» гэж шивнэн сууна.

Чингэснээ хултай айргаас хэд залгиж:

— Боохой Данзантай таарсан шигээ залуу зандан яваа ч болоосой! гэж үглэв. Тэр жилийн улсын их баяр наадамд Насан, Сэлэнгийн алдарт бөх Боохой хэмээх Данзантай үзүүр түрүү булаалдахаар гарч ирээд байжээ.

— Боохой ч хазахаас бусдыг хийдэгайхавтар хүн дээ гэсэн бөхчүүлийн яриа дуусаагүй байхад Насан гараа хэд үрчээд ойртон очив.

— Ээ дээ Данзан минь тогтож барилдаарай! гэж засуул нь өгүүлнэ. Данзан Насангийн гүйдэл дунд нь дагуулж дархан «түлхээ» мэхээ хийе гэж бодсонгүй бололтой. Насан «Хажиг мөрөө» өгүүт ганц сэжээд цахилгаан адил гялсхийн гүйв. Данзан нэг тэнцэн тогтож завдсанаа барьц алдан өргүүлжээ. Ингэж Данзан их наадамд анх дал шороодохдоо:

— Миний ид барилдаж байсан цагт таарсан ч болоосой. Энэ гулзгар хөх банди их наадмын дэвжээн дээр олон жил ганцаар тоглоно доо гэж хэлээд тахимаа өгөхдөө талархсан атаархсаны алин ч мэдэгдэлгүй өгүүлжээ

— Хөөрхий Данзан үнэн хэлсэн шүү. Би ч нэг хэсэгтээ их бага наадамд чухам ганцаар тоглосон шүү гэж эр бянтай ид залуу үеэ нэхэн дурстал:

— Арслан минь! Тавын даваа эхлэх ойртож байна шүү гэж засуулын гүйн ирж хэлэхэд Насан зодгоо авч яаран босов. Энэ үес Цоодол майхандаа тарган мах алаглуулан огтолж, үслэг гүрээгээ гүрс гүрсхийтэл айраг хол хол залгилж суужээ.

— Нутгийн ахын аманд очиж дээ Цоодол арслан минь! Насан арслан чамайг амласан дуулдана гэж нэгэн бөх ирж дуулгав. Цоодолын гэрэлтэн байсан царай хувьсхийн улайж, уурлаж улайрсан бухын нүдээр харц нь хувирав. Тэгснээчээжээ ханхалзуулан:

— Бөх явснаа надад ноднин үзүүлнэ гэж гайхуулсан юм, аргагүй дээ, зөөлхөн боорцог! Ийм боорцог ч ахиад надад таарахгүй шүү. Хэм суусан яс нь үйрчихгүй бол... Муу дүү нь нэгийг үзүүлээд өгнө өө, гайгүй хараарай! гэж өгүүлснээ бөхийн асар тийш зодоглохоор алхжээ...

— Баруун талын засуулчид сонс оо! Бөхөө амлая! гэж зүүн талын магнайд байгаа Насан арслангийн засуулч өндөр дуугаар аялгуулан дуудав. Үүний чацуу баруун талын засуулчид:

— За! гэж нэг зэрэг өндөр дуугаар хариулав.

— Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүхт... жилийн ойн их баяр наадамд барилдах саруул шаламгай, тун ч гарамгай үнэн хүчит, үлэмж баясгалант, өнөд цог нэмэх, лут бэх, маш гайхамшигт, бат ерөөлт, өлзийт дуурсах, онц түрэмгий, хичээнгүй нягт, хэтэрхий зоригт, улам өрнөх арслан Насаан! Өвөрхангай аймгийн харьяат арслан Цоодолыг амлан авч олны өмнө барин авч уран мэхийг уралдуулан

хийж хүчийг үзэн барилдъя гэв ээ гэж засуулчийн цоллоход баруун талын засуулчид «Баярлав аа» гэж хэлэв. Насан ч засуулаа хагас тойрч дэвж дэвэн тэлүүлж байв. Энэчлэн баруун талын магнай бөхийн цолыг бас дуудлаа.

Мянга гаруй бөхөөс шалгарч үлдсэн хүчтэний хэн хэнтэй учраа таарсныг нүд салгалгүй, ам булаалдан ярьж маргаж ширтсэн наадамчид ч «Төв асраас» «Уяхан замбуу тивийн наран» гэсэн сэтгэл сэргээм аялгуу хангинахын

чацуу алга нижигнүүлэв. Өөдөөс нь хоёр гараа ээлжлэн самарч тойрон байгаа Цоодолын бие Насанд нэг л хөнгөн санагдаж байв. Гэтэл яг тулаад зодгоос нь бариад халж эхлэхэд Цоодол бас ч дороо суурьтай, дотроо ухаантай нь илхэн, «Салтаа нь их зайтай харагдах нь алаг нүдний эндүү биз. Зүүн сүвэгчээр ч багтаад гүйчих залуу цаг биш шүү дээ. Гүйнгүүт зайлаад орхивол би яах вэ! Нүд хурц, хөл чанга залуугийн өмнө тоосон дунд харуулдахаас өөр замгүй. Тиймд миний хийх мэх энэ биш» гэж Насан бодно. «Лавлан барилцаж авах уу. Шуудагт нь хоёр гар хүрч барьц ханавал өөр хэрэг. Үүнээс өрсөн надад мэх хийвэл би сөхөрчхөж магадгүй. Тэгэхлээр лавцаж болохгүй».

Цоодол, зодгоос нь сэнжлэн барьж хэд халснаа арслангийн зүүн суга доогуур нь толгой гар хоёроо хийв. Барагтай л бол тас гэдрэгээ харж эргэлдэн, унагадаг «Сээрэн дунгуй» хийх гэж байгааг Насан мэдэж толгой гар хоёрыг нь хоромхноо хорьж хаав.

— Өвгөн арслан мөн ч егзөр барилдаж байна шүү. Цоодолын сээрэн дунгуйд орсон бол ч өнгөрлөө шүү гэж наадамчдын дунд яриа дэгдэв. Бүхний хараа улсын арслан, аймгийн арслан хоёрт тунажээ.

— Цоодолд буухгүй нь дээ хашир эр! Цоодол ч улсын начныг гуйж олохгүй гуядаж авах эр дээ гэж заримын мэдэмхийрэхэд:

— Өтөлснөөс өөр өө байх биш! Арслан ч үзэж тардаг нь зөвөө гэж зарим нь Насанг өмөөрнө,

Үзэгчид хоёр талцаж сэтгэлээрээ наадмын талбайд барилдах ажээ. Цоодол уран хурц мэхээ хорионд орсныг мэдэж түүнээ өөрчлөв.

Тэрцэрвүүхэн барьж аваад арсланг тонгоров. Насанг дэмжигчид түүний хамт хазайж ирлээ. «Тонгоролтыг хариулахад биеэ сулхан байлгавал сайн» гэж өвгөн арслан бодонгуутаа хөвчилж чангалсан булчин шөрмөсөө султгав. Цоодол ахин тонгоруут Насангийн зүүн хөлд дотуур дэгээ ороов. «Энэ дархан ташаа талын хөлд мөн ч олон аавын хүү дэгээ

ороосон доо. Уул нь дэнж дэвсэг нь булгичихгүй бол тэсэж өнгөрөөдөг сөн» гэж санаснаа дэгээдүүлсэн хөлөө атирснаа гэнэт хүчлэн тийрэв. Цоодолын дэгээ аргагүй мултарлаа. Насан амьсгаадах нь тун бага. Өвгөний амьсгаа үнэхээр задарсан байлаа. Харин Цоодол хэд хэдэн мэх хийсэндээ ч тэр үү амьсгаагаа дарж ядна.

— За удаж, биедээ их дасгаж болохгүй шүү. Одоо сэрмүүн барилдаж өрсөн мэх хийх зөв гэж засуулын, хэлэнгүүт Насан элэг бүснээс нь барьж аваад эргүүлэх гэтэл гурамсалж сүлжсэн мяндас тас үсрэв.

— Шив шинээрээ тас үсэрдэг байна шүү, Еэ өгөр! гэж Цоодол үглэх зуур элэг бүсээ ахиулан зангидаж залгав. «Сая би буруу мэх хийх шахлаа шүү. Элэг бүс тасраагүй бол дүүгүүрдэлтдундаа муу хөл минь сөхрөх байсан даг аа. Хүн ер нь хэзээ ухаан орж дуусдаг байна» гэж бодсоноо:

— Гарын хүч ч байна бололтой. Одоо л хийдэг хэрэг гэж арслан сэтгэлдээ шивнэв. Цоодолын зодгийн мөрнөөс сэнжлэн хэдэнтээ хүчлэн халснаа Насан тавилаа. Чингэснээ зүүн гараараа Цоодолын эгэм алгадан гэдрэг түлхэж баруун хөлийг нь шүүрэн авав. Наадмын талбай даяар «Уухай, уухай!». «Хөлөө тавьж болохгүй шүү». «Өвгөн минь гүйцээж хийнэ ээ» гэх үг шуугиан наадмын талбай түмний уухайд дээш өргөгдөх шиг болов.

— Хөл өргөөд удаж болохгүй шүү! гэж өөртөө шивнэснээ зүүн хөл дээр нь баруун хөлөөрөө хавсран цохингуут түүнийг зүүн гараараа хамав. Ингэж олон мэх угсруулан хийх талаараа онцгой явсан учир «Сүлжээ Насан» гэсэн нэрийг цөөнгүй дуулж ирсэн билээ. Цоодол ч аргагүй тоосон дунд дэмжигчдийнхээ хамт тэнгэр харлаа. Насан түүнийг ямар ч будлиан булхайгүй орхилоо... Дуу уухай... Алга ташилт...Радио хоолойгоор нэвтрүүлэгчийн ярих... Чухам юу ч дуулдахгүй болов. Арсланг тэвхийтэл үсэрч тоосноос холдож зогсоход засуул нь гүйн очижмалгайг нь өмсгөв. Насан арслан «Төв асрын» зүг алгуурхан дэвэв. Энэ хүний ханхар чээжиндюу эс багтав гэж! Бөх хүн нэгийг унагах агшиндаа дараагийн давааны амыг боддог гэлцдэг. Үнэхээр ч Насан арслангийн чээжинд«зургаагийн даваанд тун ч бузгай барилдсан Булган аймгийн Түвдэндорж гэдэг хүүг амлая. Зэгсэн бөх болох хүү шиг харагдана билээ. Түүгээр зодог тайламз. Эр хүн зорьсондоо хүрэхээс сайхан юм хаа байх вэ. Хорвоод тоос хөдөлгөж яваагаа Цоодолд ч, бөхчүүлдээ ч, наадамч дадаа үзүүллээ» гэсэн бодол

зүрхэн цохилттой зэрэгцэнэ. Зориг хүсэл, итгэл тэмүүллийн далбаа нь огтхон ч гудайгаагүй, далан насныхаа давааг давж яваа өвгөн бүргэд Насан арслан олон онд барилдаж, газар газрын хүчтэнийг орхиж омог хав, жаргал баяслаахувааж, идээний дээжийг ивээлт тэнгэрт нь өргөн явсан их наадмынхаа талбай дундуур шижир алтан соёмбо гэрэлтсэн төр улсынхаа далбааг нүд цавчилгүй ширтэж хүчит хоёр гар даль жигүүрээ дэлэн дэлсээр л байж билээ.

Хужирт
1976